ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга
✓ Аймгийн хэмжээнд нийт 14 сум, 25 агентлагийн 39 ёс зүйн дэд хороонд 133 төрийн албан хаагч ажиллаж, дэд хорооны үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлд нийт 27 удаагийн сургалтаар 1832 төрийн албан хаагчид хүрч ажилласан байна. ✓ Аймгийн Засаг даргын 2025 оны А/19 дүгээр захирамжаар Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн санхүүжилтийг баталсан. Энэ хүрээнд ёс зүйн чиглэлээр төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. ✓ Оны эхэнд нийт сум, агентлагаас өнгөрсөн онд сургалтад хамрагдсан албан хаагчийн тоон мэдээлэл болон энэ онд сургалтад хамрагдах албан хаагчийн тоо, шаардлагатай сургалтын чиглэлийн талаарх судалгааг авч нэгтгэсэн. Судалгаагаар албан хаагчдад төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйн сургалт хамгийн их хэрэгцээтэй байх тул бүх сумдад дээрх чиглэлийн сургалтыг зохион байгуулсан. ✓ Байгууллагын дотоод журамд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтыг тусган ажиллаж байна. ✓ Аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь харъяа 14 сумын ЗДТГ болон 25 газар, хэлтсийн /агентлаг/ дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөмж мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. ✓ Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг зохион байгуулах чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлж, тайлан мэдээг ирүүлсэн байдал 80 хувьтай байна.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
2.1.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд: ✓ 2025 оны 1 дүгээр сард харъяа бүтцийн нэгжийн Ёс зүйн дэд хорооны гишүүдтэй цахим уулзалт хийж, Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг тухай бүр "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэх, гомдол хүлээн авч шийдвэрлэх журам, процесс ажиллагааны талаар зөвлөмж, мэдээлэл

хүргэсэн. Мөн Ёс зүйн дэд хороодын нэгдсэн судалгааг гаргаж Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлэн, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулсан. ✓ Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж Монгол улсын Ёс зүйн хороонд хүргүүлэн ажиллав. ✓ Албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийг сахин мөрдөх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, урамшуулах зорилгоор байгууллагууд хамт олныхоо дунд “Талархлын захидал” аяныг өрнүүлж, хамгийн олон талархлын захидал хүлээн авсан албан хаагчдаа алдаршуулах, сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан.
2.1.2. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд: ✓ Төрийн жинхэнэ албан хаагчид болон төрийн үйл ажиллагааг саадгүй хэвийн явуулахад туслах үйлчилгээний албан хаагчдад чиглэсэн байдлаар тус бүр Ёс зүйн сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг хамруулсан. ✓ Аймгийн Засаг даргын тамгын газрын ёс зүйн дэд хорооны гишүүд 14 сумын ёс зүйн дэд хорооны гишүүдтэй биечлэн уулзаж, арга зүйн зөвлөмж өгч, сумдын Засаг даргын тамгын газрын нийт 923 төрийн захиргааны албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулсан. ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд 7 харъяа агентлаг, нэгжийн 332 албан хаагчид болон байгууллагадаа шинээр томилогдсон 14 албан хаагчид тус тус сургалт, мэдээлэл хүргэж ажилласан. Үүнд: Бүсийн Оношлогоо эмчилгээний төвийн эмч, сувилагч, лаборантууд, Хилийн цэргийн 0132 дугаар ангийн албан хаагчид, Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчид, Эрүүл мэндийн газрын албан хаагчид зэрэг харъяа агентлаг, нэгжүүд хамрагдсан байна. ✓ Шинээр томилогдсон 14 албан хаагчийг чиглүүлэх сургалтанд 100 хувь хамруулж, тайлант онд байгууллагадаа болон 14 сумын ЗДТГ 7 газар, хэлтсийн 1372 албан хаагч буюу нийт төрийн албан хаагчийн 27,4 хувийг хамруулсан байна.
2.1.3. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах хүрээнд: ✓ 7 байгууллагын ёс зүйн дэд хороонд холбогдох 23 гомдол мэдээлэл 2025 онд бүртгэгдэж тус дэд хороод хууль тогтоомж, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хянан шалгаж, холбогдох

ажиллагааг явуулж, 18 гомдлыг үндэслэлтэй гэж үзэн холбогдох арга хэмжээ авах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

- ✓ Иргэдээс ирүүлсэн Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг тухай бүр "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд 100 хувь бүртгэн ажиллаж байна.

2.1.4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах хүрээнд:

- ✓ Албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээнд албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон байдал, санаачилга, идэвх зүтгэл гаргах, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр манлайлсан байдлыг үнэлгээнд тусгуулан ажилласан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

- ✓ Томилох эрх бүхий албан тушаалтнаас байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал, сумдад ажиллах томилолтын зардлыг хууль тогтоомжид заасны дагуу тухай бүрд шийдвэрлэж ажилласан. Мөн албан хаагчдын ёс зүйн асуудлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг Ёс зүйн дэд хороодод тухай бүрд шилжүүлэн ажилласан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Дорнод аймгийн Ёс зүйн дэд хороод нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах чиглэлд үйл ажиллагаагаа төлөвлөн зохион байгуулж байна.

- ✓ Байгууллагын албан хаагчид болон шинээр томилогдож буй албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах
- ✓ Албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шуурхай шийдвэрлэж, хариуг хуульд заасан хугацааны дотор хүргүүлэх
- ✓ Харъяа байгууллага, бүтцийн нэгжийн төрийн албан хаагчид, Ёс зүйн дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт мэдээллээр тогтмол хангах

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
✓ 2024-2025 онд 27 удаагийн сургалтаар 1832 төрийн албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцуулж, сургалт зөвлөмжөөр хангаж ажилласан нь аймгийн нийт төрийн албан хаагчийн 36,6 хувьд хүрсэн байна. ✓ Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг төлөвшүүлж 18 албан хаагчдад ёс зүйн хариуцлага оногдуулсан нь албан хаагчдад ёс зүйн зөрчил гаргахгүй байх хөшүүрэг болж байна. ✓ Тайлант онд шинээр томилогдсон 14 албан хаагчийг чиглүүлэх сургалт, зөвлөмжөөр хангаж ажилласан.	✓ Иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийг хүлээж авах суваг тодорхой бус байна. Томилох эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан Ёс зүйн дэд хороонд хүргэгдэж байгаа нь дэд хорооны хараат бусаар ажиллах зарчимд нийцэж буй эсэхийг анхаарах шаардлагатай. ✓ Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүсэж буй ачаалал, арга хэмжээг тасалдалгүй хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангах асуудал нь төсвийн хэмнэлтийн байдлаас шалтгаалж харилцан адилгүй байна. 2025 4 дүгээр улирлаас дэд хорооны гишүүдийн урамшуулал олгогдох боломжгүй болсон ✓ Монгол улсын Ёс зүйн хорооноос дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх, чадавхижуулахад чиглэсэн сургагч багшийн сургалт болон бусад арга хэмжээний хүртээмж хангалтгүй байна.
Санал:	
1. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг төсвийн хэмнэлтэд өртүүлэлгүй, жигд олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, үйл ажиллагааг тасалдалгүй явуулах баталгааг хангах 2. Иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авах ажиллагааг цахимжуулах, холбогдох нотлох баримт, материалыг оруулж, гомдлоо харъяалах дэд хороонд шууд хүргэх боломжтой нэгдсэн сан бүрдүүлэх 3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалт, арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх	

ШАЛГАХ ХЭСЭГ:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан,
Засаг даргын тамгын газрын дарга П.Бат-Өлзий

Ёс зүйн дэд хорооны дарга,
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга У.Уранбилэг

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга,
Өрсөлдөөний зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан улсын байцаагч П.Бор-Охин

Огноо: ..2026.. оны ..01.. сарын ..05..

Байгууллагын 2025 оны ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0.8	8
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.4	4
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.7**	37
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх/гомдол ирээгүй бол 1 оноо/		1	1	10
5		Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0.7	7
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0.8	8
Хэсгийн оноо				**3**	**2.5**	25
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /гомдол ирээгүй бол 1 оноо/		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
	Үнэлгээний нийт оноо			10	9.2	92

БАТЛАВ: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА У.УРАНБИЛЭГ

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.07

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				эхний хагас жил	сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛГО 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд:							
1.1	Харьяа байгууллага, бүтцийн нэгжийн Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хууль тогтоомж сурталчилах, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, уулзалтыг бүх хэлбэрээр зохион байгуулах	Сургалт, арга хэмжээний тоо	1	2	2	1 дүгээр сар	3 дугаар сар
1.2	Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх	Үнэлгээ хийгдсэн эсэх	0	1	1	9 дүгээр сар	12 дугаар сар
1.3	Албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдөх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, алдаршуулах ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	0	1	1	10 дугаар сар	10 дугаар сар
ЗОРИЛГО 2. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд:							
2.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход	Сургалт, арга хэмжээний тоо	1	3	4	1 дүгээр сар	2 дугаар сар

	чиглэсэн ажлын байран дахь сургалтыг байгууллагын хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулах						
2.2	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулах	Хамрагдалтын хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
2.3	Харьяа байгууллага, бүтцийн нэгжийн төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн сургалт зохион байгуулах	Хамрагдалтын хувь	9,2	15	30	1 дүгээр сар	12 дугаар сар
ЗОРИЛГО 3. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах хүрээнд:							
3.1	Иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд мэдээлэх	Шийдвэрлэлтийн хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
3.2	Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэж хэвших	Бүртгэл, тайлагналтын хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
ЗОРИЛГО 4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах хүрээнд:							
4.1	Албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон байдал, санаачилга, идэвх зүтгэл гаргах, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр манлайлсан байдлыг албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээнд тооцуулах	Хийгдсэн үнэлгээний тоо	2	3	4	6 дугаар сар	12 дугаар сар

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.БОР-ОХИН

Байгууллагын 2025 оны ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0.8	8
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.4	4
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				4	3.7	37
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх/гомдол ирээгүй бол 1 оноо/		1	1	10
5		Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0.7	7
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0.8	8
Хэсгийн оноо				3	2.5	25
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /гомдол ирээгүй бол 1 оноо/		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				3	3	30
	Үнэлгээний нийт оноо			10	9.2	92

Scanned with CamScanner

БАТЛАВ: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА У.УРАНБИЛЭГ

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.07

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				эхний хагас жил	сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛГО 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд:							
1.1	Харьяа байгууллага, бүтцийн нэгжийн Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хууль тогтоомж сурталчилах, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, уулзалтыг бүх хэлбэрээр зохион байгуулах	Сургалт, арга хэмжээний тоо	1	2	2	1 дүгээр сар	3 дугаар сар
1.2	Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх	Үнэлгээ хийгдсэн эсэх	0	1	1	9 дүгээр сар	12 дугаар сар
1.3	Албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдөх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, алдаршуулах ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	0	1	1	10 дугаар сар	10 дугаар сар
ЗОРИЛГО 2. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд:							
2.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход	Сургалт, арга хэмжээний тоо	1	3	4	1 дүгээр сар	2 дугаар сар

Scanned with CamScanner

	чиглэсэн ажлын байран дахь сургалтыг байгууллагын хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулах						
2.2	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулах	Хамрагдалтын хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
2.3	Харьяа байгууллага, бүтцийн нэгжийн төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн сургалт зохион байгуулах	Хамрагдалтын хувь	9,2	15	30	1 дүгээр сар	12 дугаар сар
ЗОРИЛГО 3. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах хүрээнд:							
3.1	Иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд мэдээлэх	Шийдвэрлэлтийн хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
3.2	Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэж хэвших	Бүртгэл, тайлагналтын хувь	100	100	100	1 дүгээр сар	12 дугаар сар
ЗОРИЛГО 4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах хүрээнд:							
4.1	Албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон байдал, санаачилга, идэвх зүтгэл гаргах, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр манлайлсан байдлыг албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээнд тооцуулах	Хийгдсэн үнэлгээний тоо	2	3	4	6 дугаар сар	12 дугаар сар

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.БОР-ОХИН

Scanned with CamScanner

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга
✓ Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь нийт албан хаагчдын саналын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Б/53 дугаар тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж үйл ажиллагаагаа тасалдалгүй явуулж байна. Байгуулагдсан цагаасаа эхлэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлд нийт 27 удаагийн сургалтаар 1832 төрийн албан хаагчид хүрч ажилласан байна. ✓ 2025 оны 1 дүгээр сараас эхлэн шинэчлэн батлагдсан байгууллагын дотоод журмыг мөрдөж эхэлсэн бөгөөд Ёс зүйн дэд хороо нь чиг үүргийн дагуу дотоод журмыг шинэчлэн боловсруулах, ажилтан, албан хаагчдын саналыг нэгтгэх ажилд манлайлан оролцсон. ✓ Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь харъяа 14 сумын ЗДТГ болон 25 газар, хэлтсийн /агентлаг/ дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөмж мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
2.1.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврaар хангаж, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд: ✓ 2025 оны 1 дүгээр сард харъяа бүтцийн нэгжийн Ёс зүйн дэд хорооны гишүүдтэй цахим уулзалт хийж, Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг тухай бүр "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэх, гомдол хүлээн авч шийдвэрлэх журам, процесс ажиллагааны талаар зөвлөмж, мэдээлэл хүргэсэн. Мөн Ёс зүйн дэд хороодын нэгдсэн судалгааг гаргаж Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлэн, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулсан. ✓ Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж Монгол улсын Ёс зүйн хороонд хүргүүлэн ажиллав. ✓ Албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдөх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, урамшуулах зорилгоор хамт олны дунд “Талархлын захидал”

Scanned with CamScanner

аяныг өрнүүлж, хамгийн олон талархлын захидал хүлээн авсан албан хаагчдаа алдаршуулах, суртчилах арга хэмжээг зохион байгуулсан.

2.1.2. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд:

- ✓ Байгууллагын хэмжээнд төрийн жинхэнэ албан хаагчид болон төрийн үйл ажиллагааг саадгүй хэвийн явуулахад туслах үйлчилгээний албан хаагчдад чиглэсэн байдлаар тус бүр Ёс зүйн сургалтыг зохион байгуулж нийт 96 ажилтан, албан хаагчийг хамруулсан.
- ✓ Ёс зүйн дэд хорооны гишүүд 2025 оны эхний хагас жилд 14 сумын ёс зүйн дэд хорооны гишүүдтэй биечлэн уулзаж, арга зүйн зөвлөмж өгч, сумдын Засаг даргын тамгын газрын нийт 923 төрийн захиргааны албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулсан.
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг суртчилах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд 7 харъяа агентлаг, нэгжийн 332 албан хаагчид болон байгууллагадаа шинээр томилогдсон 14 албан хаагчид тус тус сургалт, мэдээлэл хүргэж ажилласан. Үүнд: Бүсийн Оношлогоо эмчилгээний төвийн эмч, сувилагч, лаборантууд, Хилийн цэргийн 0132 дугаар ангийн албан хаагчид, Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчид, Эрүүл мэндийн газрын албан хаагчид зэрэг харъяа агентлаг, нэгжүүд хамрагдсан байна.
- ✓ Шинээр томилогдсон 14 албан хаагчийг чиглүүлэх сургалтанд 100 хувь хамруулж, тайлант онд байгууллагадаа болон 14 сумын ЗДТГ 7 газар, хэлтсийн 1372 албан хаагч буюу нийт төрийн албан хаагчийн 27,4 хувийг хамруулсан байна.

2.1.3. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах хүрээнд:

- ✓ Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь 2025 онд хууль тогтоомж, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд иргэдээс ирүүлсэн 2 гомдол мэдээллийг хянан шалгаж, холбогдох ажиллагааг явуулж, бүрэн шийдвэрлэсэн. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэн Ө.Батбаяраас ирүүлсэн гомдлыг харъяаллын дагуу Байгаль орчны газрын Ёс зүйн дэд хороонд шилжүүлж, иргэн З.Солонгоос ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу Цагдаагийн байгууллагаас тодруулга, мэдээлэл авч, зөрчлийн хэрэг нээн шалгаж буй үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн.
- ✓ 2025 онд аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан, албан хаагчидтай дээрх 1 гомдол ирсэн, өөр гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, мөн ёс зүйн зөрчил тогтоогдоогүй байна.

Scanned with CamScanner

- ✓ Иргэдээс ирүүлсэн Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг тухай бүр "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд 100 хувь бүртгэн ажиллаж байна.

2.1.4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах хүрээнд:

- ✓ Албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний ажлын хэсэгт Ёс зүйн дэд хорооны дарга У.Уранбилэг, гишүүн Э.Отгончимэг нар ажиллаж албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон байдал, санаачилга, идэвх зүтгэл гаргах, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр манлайлсан байдлыг үнэлгээнд тусгуулан ажилласан. Байгууллагын албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ хагас, бүтэн жилээр нийт 2 удаа хийгдсэн.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

- ✓ Томилох эрх бүхий албан тушаалтнаас байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал, сумдад ажиллах томилолтын зардлыг хууль тогтоомжид заасны дагуу тухай бүрд шийдвэрлэж ажилласан. Мөн АЗДТГ-ын албан хаагчдын ёс зүйн асуудлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг Ёс зүйн дэд хороонд тухай бүрд шилжүүлэн ажилласан. Тайлант онд байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой 1 гомдол Ёс зүйн дэд хороонд ирж бүртгэгдсэн бөгөөд ёс зүйн зөрчил тогтоогдоогүй тул хариуцлагын арга хэмжээ авааагүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах чиглэлд үйл ажиллагаагаа төлөвлөн зохион байгуулж байна.

- ✓ Байгууллагын албан хаагчид болон шинээр томилогдож буй албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах
- ✓ Албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шуурхай шийдвэрлэж, хариуг хуульд заасан хугацааны дотор хүргүүлэх
- ✓ Харъяа байгууллага, бүтцийн нэгжийн төрийн албан хаагчид, Ёс зүйн дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт мэдээллээр тогтмол хангах

Scanned with CamScanner

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
✓ 2024-2025 онд 29 удаагийн сургалтаар 1832 төрийн албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцуулж, сургалт зөвлөмжөөр хангаж ажилласан нь аймгийн нийт төрийн албан хаагчийн 36,6 хувьд хүрсэн байна. ✓ 2024-2025 онд байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн зөрчил гараагүй байна. ✓ Тайлант онд байгууллагын хэмжээнд шинээр томилогдсон 14 албан хаагчийг чиглүүлэх сургалт, зөвлөмжөөр хангаж ажилласан.	✓ Иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийг хүлээж авах суваг тодорхой бус байна. Томилох эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан Ёс зүйн дэд хороонд хүргэгдэж байгаа нь дэд хорооны хараат бусаар ажиллах зарчимд нийцэж буй эсэхийг анхаарах шаардлагатай. ✓ Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүсэж буй ачаалал, арга хэмжээг тасалдалгүй хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангах асуудал нь төсвийн хэмнэлтийн байдлаас шалтгаалж харилцан адилгүй байна. Ихэнх байгууллагын дэд хорооны гишүүд урамшуулалгүй ажиллаж байгаа бол 2025 4 дүгээр улирлаас дэд хорооны гишүүдийн урамшуулал олгогдох боломжгүй болсон. ✓ Монгол улсын Ёс зүйн хорооноос дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх, чадавхижуулахад чиглэсэн сургагч багшийн сургалт болон бусад арга хэмжээний хүртээмж хангалтгүй байна.
Санал:	
1. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг төсвийн хэмнэлтэд өртүүлэлгүй, жигд олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, үйл ажиллагааг тасалдалгүй явуулах баталгааг хангах 2. Иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авах ажиллагааг цахимжуулах, холбогдох нотлох баримт, материалыг оруулж, гомдлоо харъяалах дэд хороонд шууд хүргэх боломжтой нэгдсэн сан бүрдүүлэх 3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалт, арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх	

Scanned with CamScanner

ШАЛГАХ ХЭСЭГ:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан,
Засаг даргын тамгын газрын дарга П.Бат-Өлзий

Ёс зүйн дэд хорооны дарга,
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга У.Уранбилэг

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга,
Өрсөлдөөний зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан улсын байцаагч П.Бор-Охин

Огноо: ...2026..... оны ...01... сарын ...05...

Scanned with CamScanner

ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-3040, факс: 7058-4681
Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn
Цахим хуудас: Dornod.gov.mn

2025.12.05 № 2/2592

танай 2025.10.14-ны № 1/297-т

МОНГОЛ УЛСЫН ЁС ЗҮЙН
ХОРООНЫ ДАРГА Ц.АМАРТӨГС
ТАНАА

Танай ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Ёс зүйн хорооны 2025 оны 06, 07, 08 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудастай

Хүндэтгэсэн,

ДАРГА П.БАТ-ӨЛЗИЙ

2125091576

Монгол Улсын Батлан хамгаалах яам

Цэргийн дипломат төлөөлөгчийн газар

Монгол Улсын Батлан хамгаалах яамны Цэргийн дипломат төлөөлөгчийн газрын дарга, хошууч генерал Ц.Ганбаатар

Монгол Улсын Батлан хамгаалах яамны Цэргийн дипломат төлөөлөгчийн газрын дарга, хошууч генерал Ц.Ганбаатарын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 70 дугаар албан бичгийн хавсралт.

Монгол Улсын Батлан хамгаалах яамны Цэргийн дипломат төлөөлөгчийн газрын дарга, хошууч генерал Ц.Ганбаатарын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 70 дугаар албан бичгийн хавсралт.

Хүлээн авсан:

Хүргүүлсэн: Монгол Улсын Батлан хамгаалах яам

Монгол Улсын Батлан хамгаалах яамны Цэргийн дипломат төлөөлөгчийн газрын дарга, хошууч генерал Ц.Ганбаатарын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 70 дугаар албан бичгийн хавсралт.

Монгол Улсын Батлан хамгаалах яамны Цэргийн дипломат төлөөлөгчийн газрын дарга, хошууч генерал Ц.Ганбаатарын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 70 дугаар албан бичгийн хавсралт.

2125090300

Монгол Улсын Батлан хамгаалах яам

Цэргийн дипломат төлөөлөгчийн газар

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 21000, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө 40, 40 тоот

Утас: (976) 7058 4040

И-мэйл: zzlg@dornod.gov.mn, zzlg1881@gmail.com

Вэб хуудас: www.dornod.gov.mn

Аймгийн Засаг даргын тамгын
газрын даргын 2025 оны 12 дугаар
сарын 15-ны өдрийн 1/559 дүгээр
албан бичгийн хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ 06,07,08 ДУГААР ТОГТООЛУУДЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүд албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлгээний аргачлалын дагуу хийж,үр дүнг тооцон ажиллалаа. Эрсдлийн үнэлгээний хуудсыг google form ашиглан цахимаар болон цаасан хэлбэрийг хослуулж авсан.

Тус судалгаанд хамрагдвал зохих албан хаагчдын 95,6 хувь нь хамрагдсан бөгөөд 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээний хуудас” -аар эрсдлийг үнэлж ажиллалаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний нэгтгэл

Байгууллага:

№	Тайлбар	Эрсдэлийн түвшин	Удирдах	Үүнээс эмэгтэй	Гүйцэтгэх	Үүнээс эмэгтэй	Туслах	Үүнээс эмэгтэй	Албан хаагчийн нийт тоо	Үүнээс нийт эмэгтэй албан	Эрсдэлийн түвшинд буй хамаарч албан хаагчийн
1	Нийт албан хаагч		8	5	61	28	24	7	**93**	**40**	-
2	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан албан хаагч		8	5	61	28	20	7	**89**	**40**	**95.6**
3	**А**.Төрийн албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох	1-5	4	3	33	13	18	7	**55**	**23**	**61.8**
		6-10	3	1	22	12	2	0	**27**	**13**	**30.3**
		11-15	1	1	6	3	0	0	**7**	**4**	**7,9**
		16-25	0	0	0	0	0	0	**0**	**0**	**0.0**
	А.Нийт								**61**		**65.5**
4	**Б**.Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох	1-5	39						**39**	**0**	**43.8**
		6-10	7						**7**	**0**	**7.9**
		11-15	6						**6**	**0**	**6.7**
		16-25	0						**0**	**0**	**0.0**
	Б.Нийт		**52**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**52**	**0**	

Дүгнэлт:

Эрсдлийн үнэлгээг албан тушаалын болон байгууллагын хэсгийг 2 тусад нь салгаж судалгааг авсан. Албан тушаалын эрсдлийг тооцох нийт 32 асуумжаас эрсдлийг тооцоход 61,8 хувь нь бага эрсдэлтэй, 30,1 хувь нь дунд зэргийн эрсдэлтэй, 12,4 хувь нь өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний үр дүнд эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Албан хаагчдад хийсэн үнэлгээгээр дунд зэргийн эрсдэлтэй албан хаагчдад нэмэлт хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, II түвшинд буюу өндөр эрсдэлтэй үнэлэгдсэн 7 албан хаагчаар Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулан ажилласан болно.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1.Эрсдлийн үнэлгээг улирал бүр зохион байгуулах

2.Үнэлгээний үр дүнгээс шалтгаалан хариу арга хэмжээний санал боловсруулах

3.Албан хаагчид эрсдэлтэй үнэлэгдсэн тохиолдолд ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулж байх

4.Ёс зүйн эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулах

---oOo---